

Хэрэглэгчдэд зориулсан эм хэрэглэх заавар

Фурасол 100мг

Н.Ханж  
21.09.2020

Гадуур хэрэглэх зориулалттай уусмал бэлтгэх нунтаг

Уусдаг фурагин

Танд зориулсан чухал мэдээлэл агуулсан тул эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө зааврыг сайтар уншина уу.

- Зааврыг хадгал. Танд дахин унших хэрэг гарч болно.
- Хэрэв танд ямар нэг асуулт байвал эмч, эм зүйчээс лавлана уу.
- Энэ эмийг зөвхөн таньд зориулан жоронд бичсэн. Бусдад дамжуулж болохгүй. Хэдийгээр тэдэнд тантай ижил шинж тэмдэг илэрсэн ч бусдад аюултай нөлөө үзүүлж болзошгүй.
- Хэрэв танд аль нэг гаж нөлөө илэрвэл эмч, эм зүйчид мэдэгдэнэ. Үүнд зааварт тусгагдаагүй гаж нөлөө байж болно. 4-р хэсгийг үзнэ үү.
- Хэрэв эмчилгээ эхлээд 3-5 хоногийн дараа таны бие сайжрахгүй эсвэл өвчин хүндэрч байвал эмчээс зөвлөгөө авах хэрэгтэй.

### Агуулга

1. Фурасол гэж юу вэ, юунд хэрэглэх вэ?
2. Фурасолыг хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс
3. Фурасолыг хэрхэн хэрэглэх вэ
4. Боломжит гаж нөлөө
5. Фурасолыг хэрхэн хадгалах вэ
6. Савалгааны агууламж ба бусад мэдээлэл

#### 1. Фурасол гэж юу вэ, юунд хэрэглэх вэ?

Фурасолын идэвхитэй үйлчлэгч бодис нь уусдаг фурагин бөгөөд бактерийн эсрэг (нитрофураны уламжлалт нэгдэл) үйлдэлтэй нэгдэл юм. Уг бэлдмэлийг амны хөндий болон залгиурын үрэвсэл, халдварлагдсан шарх, түлэгдэлт, идээт үрэвслийн хэсэг газарт (гадуур) угааж ашигладаг.

#### 2. Фурасолыг хэрэглэхийн өмнө мэдвэл зохих зүйлс

Дараах тохиолдолд Фурасолыг хэрэглэхийг хориглоно:

- Хэрэв та фурагин болон нитрофураны уламжлалт нэгдлүүдэд хэт мэдрэгшдэг бол (өвчний өгүүлэлмжтэй),
- Хэрэв та харшлын дерматиттай бол.

Энэ эмийн бэлдмэлийг 4-өөс доош насны хүүхдэд ам зайлахад хэрэглэж болохгүй (хүүхэд хараахан зайлж чадахгүй).

#### **Анхааруулга ба сэргэмжлүүлэг**

Энэ уусмал арьсыг шар өнгөтэй болгоно.

#### **Хүүхдэд**

Энэ эмийн бэлдмэлийг 4-өөс доош насны хүүхдэд ам зайлахад хэрэглэж болохгүй (“Фурасолыг хэрэглэж болохгүй” хэсгийг үзнэ үү).

#### **Фурасол ба бусад эмийн бэлдмэлийн харилцан үйлчлэл**

Хэрэв та өөр ямар нэгэн эм хэрэглэж байгаа, хэрэглэсэн, эсвэл хэрэглэхээр төлөвлөж байгаа бол энэ талаар эмч болон эм зүйчид мэдэгдэж зөвлөгөө авна уу.

Энэ эмийн бэлдмэл нь антибиотикийн үйлдлийг хүчтэй болгоно.

#### **Жирэмсэн ба хөхүүл үеийн хэрэглээ**

Жирэмсэн ба хөхүүл үед хэрэглэхгүй.

Хэрэв та жирэмсэн эсвэл хүүхэд хөхүүлдэг, жирэмсэн байж магадгүй эсвэл жирэмслэхээр төлөвлөж буй тохиолдолд энэхүү эмийн бэлдмэлийг хэрэглэхийн өмнө эмч болон эм зүйчээс зөвлөгөө авах хэрэгтэй.

#### **Фурасолыг архи согтууруулах ундаатай хамт хэрэглэх нь**

Эмчилгээний үед архи согтууруулах ундаа хэрэглэсэн тохиолдолд арьсны харшлын урвал илүү ихээр илэрч болзошгүй.

#### **Авто тээврийн хэрэгсэл жолоодох болон машин механизм ажиллуулах чадварт нөлөөлөх нөлөө**

Фурасол авто тээврийн хэрэгсэл жолоодох болон машин механизм ажиллуулахад нөлөө үзүүлэхгүй.

### **3. Фурасолыг хэрхэн хэрэглэх вэ**

Эмийн бэлдмэлийг энэ зааварт бичсэнээр эмч, эм зүйчийн зааврыг ягштал баримтлан хэрэглэнэ. Хэрэв та итгэлгүй бол эмч, эм зүйчээс асуугаарай.

Уусмалыг яг хэрэглэхийн өмнө найруулна. Бэлтгэсэн уусмалыг хадгалж болохгүй!

### Амны хөндий болон залгиурын үрэвсэл

Нэг уутан дахь нунтгийг нэг аяга халуун, буцалсан усанд (200мл) уусгаад бүлээн уусмалаар өдөрт 2-3 удаа зайлна.

### Халдвартлагдсан шарх, тулэгдэлт, идэээт үрэвслийн үед

Нэг уутан дахь нунтгийг нэг аяга халуун, буцалсан усанд эсвэл нэрсэн усанд (200мл) уусгана. Уусмалыг халдвартлагдсан шарх, түлэгдэлт, идэээт үрэвслийг өдөрт 1-2 удаа угааж хэрэглэнэ.

### **4. Боломжит гаж нөлөө**

Бусад бүх эмийн бэлдмэлийн нэгэн адил фурасол гаж нөлөө үзүүлж болно.

Зарим тохиолдолд уусмалын нөлөөгөөр арьсны харшлын урвал илэрч болзошгүй (“Фурасолыг архи согтууруулах ундаатай хамт хэрэглэх нь” хэсгийг үзнэ үү). Энэ тохиолдолд эмийн бэлдмэлийг хэрэглэхээ яаралтай зогсоож, шаардлагатай тохиолдолд эмчийн зөвлөгөө авна уу.

### **5. Фурасолыг хэрхэн хадгалах вэ**

25°C ихгүй хэмд хадгална.

Гэрлийн тусгал, чийгнээс хамгаалан өөрийн саванд хадгална.

Эмийг хүүхэд хүрэхгүй газарт хадгална.

Хэрэв савлагаа гэмтсэн бол бэлдмэлийг хэрэглэж болохгүй.

Цаасан хайрцагт заасан хугацаа дууссан бэлдмэлийг хэрэглэхгүй.

Үүнд дуусах хугацааны сар, өдрийг бичсэн байна. Хүчинтэй хугацаа нь тухайн сарын сүүлийн өдрийг заана.

### **6. Савалгааны агууламж ба бусад мэдээлэл**

#### **Фурасолын найрлага**

Идэвхитэй үйлчлэгч бодис нь уусдаг фурагин юм.

Нэг уутанд 100мг уусдаг фурагин агуулагдах ба 87,4мг фурагинтай тэнцэнэ.

Бэлдмэлд агуулагдах бусад нэгдэл нь натрийн хлорид юм.

#### **Фурасолын дүрслэл ба савлалт**

Ламинаталсан уутанд улбар шар-бор өнгийн мөхлөгт нунтаг.

5 буюу 15 ширхэг ламинаталсан ууттай бэлдмэлийг эм хэрэглэх зааврын хамтаар хатуу цаасан хайрцагт савласан байна.

**Маркетингийн зөвшөөрөл эзэмшигч ба үйлдвэрлэгч**

Компанийн нэр: Joint-Stock Company "OLAINFARM"

Хаяг: 5, Rupnicu St., Olaine, LV-2114, Latvia.

Утас: +371 67013705

Fax +371 67013777

e-mail: [olainfarm@olainfarm.com](mailto:olainfarm@olainfarm.com)